

БАТЛАВ:  
НИЙСЛЭЛИЙН ЗАМ ТЭЭВРИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ

БОТГОНСУХ

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ДУГУЙН ЗАМ ШИНЭЭР БАРИХ АЖЛЫН ЗУРАГ  
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

Дугаар 3Д2020/001

ЗӨВШӨӨРСӨН:  
НИЙСЛЭЛИЙН АВТО  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

111026578 29115064

Б.ИНДРА

1.Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9/36 тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/1359, НЗД-ын 2020 оны 02 дугаар сарын 03 ны өдрийн А/133 дугаар захирамж,
2. Байршил	БЗД, БГД, СХД, ЧД, НД, ХУД, СБД-ийн нутаг дэвсгэр
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн төсөв
4.Замын техникийн ангилал, замын зэрэг	Дугуйн зам,
5.Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8.Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9.Захиалагч байгууллага	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
10.Зураг төслийн иж бүрдэл	<ol style="list-style-type: none"><li>Инженер геодезийн ажлын тайлан</li><li>Инженер-геологийн судалгааны ажлын тайлан</li><li>Дугуйн замын ажлын зураг төсөл</li><li>Тайлбар бичиг (Трасс сонголт, төлөвлөлтийн хувилбар, холбогдох норм ба дүрэм, төлөвлөлтийн шийдлийн талаар, төслийн товч танилцуулга, ажлын тоо хэмжээ, хучилтын бүтээц, тооцоо, магадлалын ерөнхий дүгнэлт)</li><li>Техникийн шаардлага</li><li>Барилгын ажлын нэгдсэн төсөв</li></ol>

**11. Онцгой нөхцөл:**


- Зураг төсөл боловсруулахдаа Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016”, “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”MNS 4597: 2014, “Авто замын тэмдэглэл” MNS4759:2014, “Авто замын гэрлэн дохио” MNS 4980:2014, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх. Мөн олон улсад хэрэглэгдэж буй дугуйн замын стандартыг судалж үндэслэл болгох.
- Дугуйн замын трасс сонголтыг нарийвчлан судалж тухайн төлөвлөлтийн хувилбаруудын давуу болон сул талыг тооцох, захиалагч байгууллага болон холбогдох байгууллагуудаас саналыг авч баталгаажуулах.
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, ”Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх.
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцогоор оновчтой сонгох. /Газрын нөхцөлөөс хамаарч тус судалгааг хийх/
- Гадаргуугийн ус зайлцуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ- тай зөвшилцөх
- Явган хүний зам, амрах талбай, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн ус зайлцуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.
- Дугуйн замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлцуулах бол тусгах.

- Уулзвар, гарц дээрх хөдөлгөөн зохион байгуулалтын онцгойлон анхаарах.
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах.
- Дугуйн замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан “LED” технологиор шийдвэрлэх /гудамж замын онцлогт байдлаас хамаарч гэрэлтүүлэгтэй эсэхийг шийдэх/
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:
 

Дэвсгэр зураг	1:250-1000
Хөндлөн огтлол	1:20-100
Өндөржилт	1:500-1000
Уулзвар, огтлолцол	1:250-500
Бүтээц	1:20
- Дугуйн зам, дугуйн зогсоол, амрах талбай, сүүдрэвч, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө
- Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, гүүр хоолой, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглээ, инженерийн шугам сүлжээ, ус зайлуулах байгууламж, явган зам гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- НХБХГ-ын авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар, НАЗХГ-ын авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах.
- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, УБЗАА, ЗХУТ-тэй тус тус зөвшшилцөний үндсэн дээр холбогдох газруудаас санал авч зураг төслийг баталгаажуулах.

**Хянасан:**

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын  
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

 /О.Энхбаатар/


**Боловсруулсан:**

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын  
Хэлтсийн ахлах мэргэжилтэн

 /Б.Анхбаяр/

2020 оны.....сарын.....-ны өдөр

10 ДУГААР ХОРОООЛЫН УУЛЗВАРААС НОГООН НУУРЫН ГУДАМЖ ХҮРТЭЛХ ДУГУЙН ЗАМ  
/ЭТӨЧ, ИХ ТОЙРУУ, Э ГАЛДАНБОШГОТЫН ГУДАМЖ/



**Хянасан:**

НАЗХГ-ЫН Бодлого, зохицуулалтын  
хэлтсийн дартын үүргийг түр орлон гүйцэтгэгч.....*Оюунжиро* Энхбаатар/

**Боловсруулсан:**

НАЗХГ-ЫН Бодлого, зохицуулалтын  
Хэлтсийн ахлах мэргэжилтэн  
*Б.Анхбаяр/*

ТЭЭВРИЙН ДЭЭД СУРГУУЛИАС ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ ХҮРТЭЛХ ДУГҮЙН ЗАМ /СӨҮЛИЙН ГУДАМЖ ДАГУУ/



Хянасан:

НАЗХГ-ЫН Бодлого, зохицуулалтын  
хэлтсийн даргын уургийг тур орлон гүйцэтгэгч.....  
/О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ЫН Бодлого, зохицуулалтын  
Хэлтсийн ахлах мэргэжилтэн

/Б.Анхбаяр/